



# "ТҮРЭГ СУДЛАЛ" СЭДЭВТ ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД УРЬЖ БАЙНА



МУИС, ШУС, ХУС Ази судлалын тэнхим, “Түрэг судлал”-ын салбар, түүний дэргэдэх Нүүдэлчдийн утга соёлын “Таван ухаан” клуб хамтран “Түрэг судлалын салбар үүсгэн байгуулагдсаны 20 жил, Руни бичгийг уншиж тайлсны 128 жилийн ой”-г тохиолдуулан “ТҮРЭГ СУДЛАЛ” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний хурлыг нийт их, дээд сургууль, коллежийн оюутан залуусын /бакалавр/ дунд уламжлал ёсоор зарлаж байна.

Оюутны эрдэм шинжилгээний хурал **2021 оны 12 дүгээр сарын 15-ны** өдөр зохион байгуулах анги цагийг илтгэгчийн цахим хаягаар мэдээлнэ.

- Илтгэлийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр 2021 оны 12-р сарын 10 /Баасан гариг/18:00 цаг хүртэл МУИС-ийн хичээлийн II байр, 4 давхар, 414 тоотод хүлээн авна.
- Цахим хэлбэрийн зарлалыг [www.num.edu.mn](http://www.num.edu.mn) сайтаас үзнэ үү.

## Тавигдах шаардлага:

1. Илтгэлийг урьд өмнө хэлэлцүүлээгүй байх
2. Илтгэлийг хэвлэмэл болон цахим байдлаар ирүүлэх( [solongob0402@gmail.com](mailto:solongob0402@gmail.com) )
3. Илтгэлийг MSW программ дээр **Times New Roman** фондоор бичих
4. Хуудсын хэмжээ-A4, үсгийн өндөр 10pt, мөр хоорондын зай /Single/ байхаас гадна бичвэрийн хоёр талыг тэгшлэх/**Justify**/
5. Илтгэгчийн нэр, хаяг, холбоо барих утас, удирдагчийн зэрэг, цолыг тодорхой бичиж ирүүлэх
6. Дээрх бичиглэлийн шаардлагыг бүрэн биелүүлсэн байх
7. Илтгэгч итгэлийнхээ агуулгыг MSP программ дээр товч хэлбэрээр бэлтгэсэн байх

**Жич:** *Хугацаа хоцорсон илтгэлийг хүлээн авахгүй.*

## Шагнал:

- **I байр.** Өргөмжлөл, мөнгөн шагнал, судалгаа шинжилгээний номын дээж
- **II байр,** Өргөмжлөл мөнгөн шагнал, судалгаа шинжилгээний номын дээж
- **III байр.** Өргөмжлөл, мөнгөн шагнал, судалгаа шинжилгээний номын дээж
- **Тусгай байр.** Өргөмжлөл, мөнгөн шагнал, судалгаа шинжилгээний номын дээж

*Дэлгэрэнгүй мэдээллийг МУИС-ийн хичээлийн II байрын 414 тоотоос лавлана уу.*

**Харилцах утас:** +976-85551210, 77307730 (2208-код)

**Түрэг судлалын салбар  
Нүүдэлчдийн Утга Соёлын “Таван Ухаан” клуб**

**2021.11.04**